# НАЛАЙХ ДҮҮРГИЙН V-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ "МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК-НИЙ ДЭНЖИЙН ЭЛС-1 УУЛЫН ХЭСГИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан:

" БОУАӨЯ"-ны ХБОБХГ-ын мэргэжилтэн /.........................../

"Нийслэлийн Байгаль орчны газар"-ын мэргэжилтэн /.........................../

Хэрэгжилтийг тайлагнасан:

"Монголын алт" (МАК) ХХК
"Евро блок үйлдвэр" -ийн дарга Б. Бадамдамдин

Боловсруулсан:

"Монголын алт" МАК (ХХК)-ийн
"Евро блок үйлдвэр" -ийн Байгаль орчны мэргэжилтэн Б. Дашням

2024 он

# ГАРЧИГ


**1.** ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА........................................................... **2**

1.1 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.................... **9**

1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ............................................................ **14**

**2** СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..................................................................... **15**

**3** НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ......................... **26**

**4** ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ................................................................................................ **28**

**5** НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ........................................... **30**

**6** ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ...................................................................... **30**

**7** ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ................................................................................................ **30**

**8.** ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ................................................................................................ **32**

**9** ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ........................................................................................ **34**

**10** УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ................................................................................................ **38**

**11** ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ............................................................................................ **39**

**12** ДҮГНЭЛТ.............................................................................................. **40**

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД.......................................................................... **41**

# ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Компанийн танилцуулга:**

Монголын Алт" (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Дэнжийн элс уурхайн зорилго:**

Уурхай нь Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн эрдэс, түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох, ажлын байрыг нэмэгдүүлэх, уул уурхай, барилгын салбарын өсөн нэмэгдэж буй түүхий эдийн хэрэгцээг хангах юм.

**Газар зүйн байршил:**

Дэнжийн элс–1 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Дэнжийн элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт, Улаанбаатар хотын төвөөс 60 км–т, Налайх дүүргийн төвөөс 15 км–т Зуун модны элсний ордтой зэргэлдээ оршино.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар MV015573A. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон нийт талбайн хэмжээ 33.77 га болно.

Анх Дэнжийн элс-1 нэртэй талбайн 12748X тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг "Ашигт малтмалын тухай" Монгол улсын хуулийн дагуу АМГТХЭГ-ын Кадастрын бүртгэлийн төвийн даргын 2007 оны 2213 тоот шийдвэрээр "Монголын Алт" (МАК) ХХК-д "Гипфель" ХХК-ийн эзэмшиж байсан 9973X тоот тусгай зөвшөөрлөөс хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн олгосон.

Хайгуулын ажлын дүнд "Дэнжийн элс"-ний ордын элсний бодитой (B) нөөцийг 221.327.36 $м^3$, хайрганы бодитой нөөцийг (B) 5.675.06 $м^3$, элсний (C) боломжтой нөөцийг 316.684.07 $м^3$, хайрганы боломжтой нөөцийг 6.814.94 $м^3$ гэж тогтоосон. Ордын нийт элсний нөөц нь 538011.37 $м^3$, хайрганы нийт нөөц 12.490.0 $м^3$ болж байна.

"Монголын Алт" ХХК-ийн "Дэнжийн элс"-ний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд уурхай нь зам тээвэр, цахилгаан, харилцаа холбооны бүхий л хэлбэрийг ашиглах боломжтой, дэд бүтцийн хөгжил сайтай бүсэд оршдог.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн газар зүйн солбилцол:

1. 107° 29' 30.4' ' 47° 47' 59.2'
2. 107° 29' 00.4' ' 47° 47' 59.2'
3. 107° 29' 00.4' ' 47° 48' 16.8'
4. 107° 29' 30.4' ' 47° 48' 16.8'



***Зураг 1 Талбайн байршил***



***Зураг 2 Уурхайн харагдах байдал***

**Цахилгаан хангамж**

Уулын хэсгийн тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүч, ажилчдын байрны гэрэлтүүлгийг 35 кВ-ын ЦДАШ, 35/04 кВ-ын 2 дэд станцаас хангаж байна. Нийт хүчин чадал нь 410 кВА бөгөөд үндсэн цахилгаан хангамж тасалдах, гэмтэх зэрэг эрсдэлээс сэргийлэн нэмэлтээр дизель генераторыг суурилуулж ажиллаж байна.



*Зураг 3 Цахилгаан хангамж болон Аваарын дизель генератор*

**Усан хангамж**

Элс угаах үйлдвэрийн технологи болон ажилчдын ахуйн хэрэглээний усыг гүний худгаас хангадаг ба одоогийн байдлаар 2014, 2022, 2023 онуудад гаргуулсан 3 худгийг үйлдвэрлэл, унд ахуйд ашиглаж байна. Гүний худаг бүр насос болон баталгаажуулсан тоолууртай. Тухайн оны ус ашиглалтын дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, гэрээг  холбогдох сав газартай байгуулан гэрээний үүргээ биелүүлж ажилладаг. Элс угаах төхөөрөмжийн усны хэрэглээг багасгах зорилгоор ашигласан усаа хуримтлуулж дахин элс угаахад ашиглаж байна.

**Гадаад тээвэр**

Бэлэн бүтээгдэхүүнийг Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн 4-р зөрлөгт орших орших МАК Евро блок үйлдвэр хүртэл улсын чанартай авто зам болон өөрийн сайжруулсан шороон замуудаар тээвэрлэж байна. Замын нийт трассын урт 32 км байх ба уурхайн талбайгаас төв зам хүртэл нийт 0.85 км зайд оршдог.

## Уурхайд ашиглагдсан техник тоног төхөөрөмж

Уурхайд Орос, Герман, Япон зэрэг улсад үйлдвэрлэгдсэн техник, тоног төхөөрөмжийг ашигладаг. 2024 онд ашигласан техник, тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 1 Уурхайд ашигласан техник, тоног төхөөрөмж*

| № | Техник, тоног төхөөрөмж | Хүчин чадал | Тоо хэмжээ /ш/ |
|---|---|---|---|
| 1 | HITACHI -ZX360H экскаватор | 1,6 | 1 |
| 2 | XGMA 951H утгуурт ачигч | 3м$^3$ | 1 |
| 3 | TONLI | 25 тн | 2 |
| 4 | TONLI | 32тн | 1 |
| 5 | NORD BENZ- 25 тн | 18 м$^3$ | 3 |
| 6 | PiCkUP үйлчилгээний машин | 1 тн | 1 |
| 7 | Нийт | | 9 |



*Зураг 4 Hitachi -ZX360H экскаватор*



*Зураг 5 XGMA 951H утгуурт ачигч*



*Зураг 6 Tonly*



*Зураг 7 Nord benz- 25 тн*

**Элс ангилан ялгаж, угаах тоног төхөөрөмжийн ажиллагаа**

Уулын хэсгээс автосамосвалаар бохир элс тээвэрлэж, элс хүлээн авах бункерт буулгаж уг бункерээс туузан дамжуургаар элс хуримтлуулах бункерт хүргэж хуримтлуулах бункерээс туузан дамжуургаар элс ангилан ялгах төхөөрөмжид хүргэгдэж элс хайргыг 5мм-ээс их, бага хэмжээтэй фракцаар ялгана.

Хаягдал хайрга буюу 5 мм-с дээш хэмжээтэй хаягдал хайрга нь овоолгын туузан дамжуургаар хаягдал хайрганы овоолго үүсгэнэ. Ангилсан элсийг (5мм-с бага хэмжээтэй) угаах төхөөрөмжид өгч холигч шурган голоор угааж элс хатаах төхөөрөмжид хүргэж уг төхөөрөмжөөс туузан дамжуургаар дамжин угаасан элсний овоолго үүсгэнэ.

***Хүснэгт 2 Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд***

| № | Техник, тоног төхөөрөмж | Хүчин чадал | Тоо хэмжээ /ш/ |
|---|---|---|---|
| **1** | Хүрдэт шигшүүр | 20 т/цаг | 1 |
| **2** | Туузан конвейр | 130 т/цаг | 3 |
| **3** | Элс угаах төхөөрөмж XS1000*6000 | 140т/цаг | 1 |
| **4** | Элс угаах төхөөрөмж | 200т/цаг | 1 |

***Схем 1 Элс шигших, ангилах, угаах технологи***



**Ажиллах хүчний мэдээлэл**

Уулын хэсгийн элс угаах төхөөрөмж 5-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэлх хугацаанд 2- ээлжээр ажилласан ба уурхай нь хүйтний улиралд 12 дугаар сарын 15 аас 2 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд амарсан. Бүтэц, орон тоогоор 42 ажилтантай байхаар тусгагдсан ба одоогоор 31 ажилтан ажиллаж байна.

***Хүснэгт 3 Ажилласан хүний нөөцийн мэдээлэл***

| № | Албан тушаал | Орон тоо | Жилд ажиллах сар |
|---|---|---|---|
| 1 | Уулын хэсгийн дарга | 1 | 12 |
| 2 | Баяжуулагч инженер | 1 | 12 |
| 3 | Уулын инженер | 1 | 12 |
| 4 | Машин механизм | 1 | 12 |
| 5 | Уулын мастер | 2 | 12 |
| 6 | Цахилгааны мастер | 1 | 10 |
| 7 | Засварын мастер | 1 | 10 |
| 8 | Экскаватор оператор | 2 | 10 |
| 9 | Дугуйт ачигчийн оператор | 6 | 10 |
| 10 | Үйлчилгээний машины жолооч | 1 | 10 |
| 11 | Автосамосвол | 4 | 10 |
| 12 | Автобусны жолооч | 1 | 10 |
| 13 | Тусгай зориулалтын жолооч | 1 | 12 |
| 14 | Шигшүүрийн оператор | 6 | 12 |
| 15 | Автогрейдер | 1 | 12 |
| 16 | Гагнуурчин | 1 | 12 |
| | Нийт | 31 | |

**Барилга байгууламж**

Ил уурхайн бүрэлдэхүүнд түүний үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой дараах объектуудыг барьж байгуулсан. Үүнд:

- Элсний ил уурхай, хөрсний овоолго, шимт хөрсний овоолго
- Засвар үйлчилгээний төв
- Ажилчдын зоогийн газар
- Сэлбэг хэрэгслийн агуулах

**Сэлбэг хэрэгслийн агуулах**

Сэлбэг хэрэгсэл болон материал хадгалах 2 агуулахтай ба тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, сэлбэг хэрэгсэл зэргийг хадгалах 50х50 метрийн хэмжээтэй задгай

талбай байгуулсан. Уурхайн тоног төхөөрөмж, машин техникийн шатах тослох материал, шатахууныг Евро блокны үйлдвэрээс хангаж байна.

**Захиргаа ба ажилчдын хооллох түр амрах байр**

2023 онд Засвар үйлчилгээний төв болон захиргааны байрыг сайжруулсан ба ажилчдын зоогийн газрыг шинээр 340,81 м$^2$ талбайд барьж ашиглалтад оруулан ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.





*Зураг 8,9 Засвар үйлчилгээний төв, Зоогийн газар*



*Зураг 10 Ажилчдын түр амрах байр*



*Зураг 11 Хооллох хэсэг*



*Зураг 12 Сэлбэгийн агуулах*



*Зураг 13 35/04 шугамын дэд станц*

**Нэгдсэн менежментийн тогтолцоо:** МАК Евро блок үйлдвэр болон Дэнжийн элс уудын хэсэг нь 2022 оны 12 сарын 30 нд **ISO 9001:2015** "Чанарын менежментийн тогтолцоо", **ISO 45001:2018** "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо, **ISO 14001:2015** Байгаль орчны менежментийн тогтолцоо олон улсын стандартуудын аудитаа амжилттай хамгаалж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.




*Зураг 14 Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ*

## 1.1 ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Дэнжийн элс, Дэнжийн элс-1 уулын хэсгийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2024 оны БОННҮ-ний нэмэлт тодотголоор дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал

*Хүснэгт 4 Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцлүүд*

| Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд | Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд |
|---|---|
| **Төслийн байршилтай холбоотой шалгуурууд** | |
| Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх; | - Орон нутагт салхины нөлөө ихтэй ба хүчтэй салхи шуурга үе үе болдог;<br>- Ил уурхайн олборлолтын технологийн үе шатуудаас болон элс угаах үйлдвэрийн үйл ажиллагаанаас богино хугацаанд эрчим ихтэй тоосжилт үүсэж болзошгүй;<br>- Хөрсний эвдрэл үүсэж болзошгүй;<br>- Газар хөдлөлтийн VII баллын бүсэд оршиж байгаа; |
| Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх | Орон зайн хувьд нөлөөллийн цар хүрээ цаашид тэлэхгүй бөгөөд харин төсөл хэрэгжих явцад тухайн орчинд өөр төслүүд зэрэгцүүлэн хэрэгжих тохиолдолд хуримтлагдах нөлөөлөл |

| | |
|---|---|
| Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгалт зүйлүүдэд нөлөөлөл үүсэх | Төслийн талбай нь ГТБЦГ-ын хязгаарлалтын бүсээс урагшаа 1.6 км зайд байрлана. |
| **Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд** | |
| Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:<br>- Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх<br>- Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, | Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх дараах эх үүсвэрүүд байна. Үүнд:<br>- Ил уурхайн ачилт, тээвэрлэлтээс үүсэх тоосжилт;<br>- Элсийг Евро блокын үйлдвэр луу хүргэх тээвэрлэлтээс үүсэх тоосжилт;<br>- Дуу чимээ болон доргилт үүснэ; |
| Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:<br>- Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх;<br>- Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх;<br>- Ус бохирдуулах, эсэх; | Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө:<br>- Ашиглалтын үед шаардагдах технологийн хэрэгцээний болон ахуйн хэрэглээний усыг талбайд гаргасан 3 гүний худгаар хангана/ус хэрэглээг хангаж чадахгүй үед Евро блокын үйлдвэрийн худгууд болон конденсацийн уснаас хангахаар төлөвлөж байгаа/;<br>- Ахуйн бохир усыг цооногт хадгалах үед ханаар нэвчих, дүүрсэн үед халих замаар хөрсөнд нэвчих;<br>- Ил уурхай, үйлдвэрийн технологийн усны хэрэглээ ба унд-ахуйн зориулалтаар хоногт 1345.6 $м^3$, жилд 229,128 $м^3$ цэвэр ус зарцуулахаар байна. |
| Газрын хэвлий | - Уурхайлалтын хүрээнд 120.9 мян.$м^3$ хөрс байх бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.04 $м^3$ /$м^3$ байна. Уурхайн хүрээн дэх нийт уулын цулын хэмжээ 3.3 сая.$м^3$ байна.<br>- 0.5 метр зузаан хөрсний үеэр хучигдсан бөгөөд ашиглалтын хугацаанд тээвэртэй ашиглалтын технологи (Урвуу утгуурт экскаватор, автосамосвалын хослол) ашиглан Дэнжийн элс-1 талбайгаас 105.9 мян.$м^3$ , Дэнжийн элс талбайгаас 15.01 мян.$м^3$ , нийт 120.91 мян.$м^3$ хөрс хуулалт хийж гадаад болон дотоод овоолго үүсгэнэ. |
| Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:<br>- Хөрс эвдрэх эсэх;<br>- Хөрс бохирдох эсэх;<br>- Хөрс доройтох, цөлжих эсэх; | Хөрсөн бүрхэвчид дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:<br>- Ил уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлтийн үед талхалж доройтуулах;<br>- Ил уурхайн машин механизмаас тос, шингэн асгарах;<br>- Хатуу хог хаягдал гарах;<br>- Дотоод, гадаад зам үүсгэснээр хөрс эвдрэх;<br>- Уурхай, барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдэгдэх; |

| | |
|---|---|
| Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө:<br>- Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх<br>- Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх | Ургамлан нөмрөгт дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөлтэй. Үүнд:<br>- Хөрс хуулснаар ургамлан нөмрөг биет хэмжээгээр устаж, тодорхой хэмжээний газар талбайд нөмрөг ургамалгүй болох;<br>- Газрын хөрс талхлагдсан газруудад ургамлан нөмрөг халцрах;<br>- Уурхайлалтын үеийн тоосны нөлөөгөөр ургамлын ургах орчин доройтох;<br>- Төсөл хэрэгжих талбайд ховор болон нэн ховор ургамал тэмдэглэгдээгүй тул төрөл зүйлд нөлөө үзүүлэхгүй. |
| Ан, амьтанд үзүүлэх нөлөөлөл:<br>- Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, эсэх;<br>- Ховор болон нэн ховор амьтан өртөх, эсэх; | Ан амьтдад сөрөг нөлөө үзүүлэх дараах нөхцөлүүд байна.<br>- Үйл ажиллагааны үед төслийн талбай орчмын амьтад дүрвэж дайжих;<br>- агаарын цахилгаан дамжуулах шугам сүлжээнд шувуу өртөх;<br>- дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх;<br>- Тунгаагуур нуурны уснаас мал амьтан уух<br>- Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх; |

Төслийн байгаль орчны нөлөөллийн гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөлийн хэлбэр, эрчим, үргэлжилэх хугацааг магадлан жагсаах аргаар үнэлж дараах хүснэгтээр үзүүлж байна.

***Хүснэгт 5 Нөлөөллийг тодорхойлол шалгуур үзүүлэлтүүд***

| № | Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд | Нөлөөллийн хэлбэр | | Нөлөөллийн эрчим | | | | Үргэлжлэх хугацаа | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Нөлөөлөл байхгүй бага | дунд | Их | Түр зуурын (1 жилээс доош) | Богино хугацааны (1-5 жил) | Дунд хугацааны (5-15 жил) | Урт хугацааны |
| **Төслийн байршилтай холбоотой шалгуурууд** | | | | | | | | | | | |
| **1** | Хүний нөлөө байгаа эсэх | | x | | x | | | | x | | |
| **2** | Байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх; | | x | | | x | | | | | x |
| **3** | Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар | | x | x | x | | | | | | x |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа эсэх | | | | | | | | | | |
| **Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд** | | | | | | | | | | | |
| **4** | Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх | | x | | x | | | | | | x |
| **5** | Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх | x | | | | x | | | | | x |
| **6** | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх; | | x | | x | | | | x | | |
| **7** | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх; | x | | | x | | | | | | x |
| **8** | Ус бохирдуулах, эсэх; | | x | | x | | | | | | x |
| **9** | Хөрс эвдрэх эсэх; | x | | | | | x | | | | x |
| **10** | Хөрс бохирдох эсэх | | x | | x | | | | x | | |
| **11** | Хөрс доройтох, цөлжих эсэх; | | x | | x | | | x | | | |
| **12** | Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх | | x | | | | x | x | | | |
| **13** | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх | | x | | x | | | x | | | |
| **14** | Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, эсэх; | | x | | x | | | x | | | |
| **15** | Ховор болон нэн ховор амьтан өртөх, эсэх; | | x | | x | | | x | | | |
| **Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд:** | | | | | | | | | | | |
| **16** | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх; | | x | | | x | | | x | | |
| **17** | Оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөтэй, эсэх; | | x | x | | x | | x | | | |
| **18** | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв суурин газар байгаа, эсэх; | | x | | | x | | x | | | |
| **19** | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх; | | x | | x | | | | | | x |
| **20** | Түүх соёлын өвд үзүүлэх нөлөөлөл | | x | | x | | | | | | x |
| **21** | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, эсэх; | | x | | | x | | | x | | |
| **22** | Төслийн бүхий л үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх, эсэх; | | x | | | x | | | | | x |
| | Дүн: | 3 | 19 | 2 | 12 | 8 | 2 | 7 | 5 | 0 | 8 |

Дээрх дүнгээс үзэхэд 22 нөлөөллийн 3 нь шууд, 19 нь шууд бус харин 2 нь өөрөөр зохицуулагдах хэлбэртэй байна. Нийт нөлөөллийн 50% нь нөлөөлөлгүй буюу багатай, 40.9% нь дунд зэргийн нөлөөлөлтэй байхад 9.09% нь их нөлөөлөл үзүүлж байна. Нөлөөлийн үр дүнгийн 63.6% нь түр зуурын ба богино хугацааных бол 36.36% нь урт хугацааны нөлөөлөл байна

***Хүснэгт 6*** **Байгаль орчны болзошгүй нөлөөллийн үнэлгээний нэгтгэл**

| Нөлөөллийн төрөл | Эрчим | Үргэлжлэх хугацаа | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны эзлэх хувь % | Нөлөөллийн зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт** | | | | | | | |
| Усны чанарын өөрчлөлт | 2 | 3 | 1 | 2 | 8 | 32 | Дунд |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | 3 | 4 | 1 | 4 | 12 | 48 | Дунд |
| Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол | 2 | 4 | 1 | 4 | 11 | 44 | Дунд |
| Геологийн тогтцын өөрчлөлт | 2 | 4 | 1 | 5 | 12 | 48 | Дунд |
| Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт | 1 | 4 | 1 | 2 | 8 | 32 | Дунд |
| Агаарын орчин /бохирдол/ | 8 | 4 | 1 | 4 | 17 | 68 | Дунд |
| Газар доорх усны нөөц | 6 | 4 | 2 | 3 | 15 | 60 | Дунд |
| **Дундаж** | | | | | | **47.4** | Дунд |
| **2. Байгалийн нөөцийн ашиглалт** | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | 1 | 4 | 2 | 5 | 12 | 48 | Дунд |
| Бэлчээр, тэжээлийн байдал | 2 | 4 | 1 | 1 | 8 | 32 | Дунд |
| Эрдэс түүхий эдийн нөөц | 8 | 4 | 1 | 5 | 18 | 72 | Дунд |
| **Дундаж** | | | | | | **50.7** | Дунд |
| **3. Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт** | | | | | | | |
| Ундны усны чанар, хэмжээ | 4 | 4 | 1 | 2 | 11 | 44 | Дунд |
| Хөрсний бохирдол | 2 | 3 | 1 | 2 | 8 | 32 | Дунд |
| Агаарын чанар | 6 | 4 | 1 | 4 | 15 | 60 | Дунд |
| Дуу чимээ, шуугианы нөлөөлөл | 2 | 4 | 1 | 2 | 9 | 36 | Дунд |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | + | | | | | | + |
| Орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх | + | | | | | | + |
| **Дундаж** | | | | | | **43.0** | Дунд |
| **4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл** | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх | - | - | - | - | - | - | - |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | - | - | - | - | - | - | - |
| Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх | - | - | - | - | - | - | - |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | 2 | 4 | 1 | 1 | 6 | 24 | Бага |

| Нөлөөллийн төрөл | Эрчим | Үргэлжлэх хугацаа | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны эзлэх хувь % | Нөлөөллийн зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх | 1 | 4 | 1 | 2 | 7 | 28 | Бага |
| **Дундаж** | | | | | | **26.0** | Бага |
| **5. Бусад нөлөөлөл** | | | | | | | |
| Тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх | 2 | 2 | 1 | 2 | 7 | 28 | Бага |
| Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих | 2 | 1 | 1 | 2 | 6 | 24 | Бага |
| Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга | 2 | 1 | 1 | 2 | 6 | 24 | Бага |
| **Дундаж** | | | | | | **25.3** | Бага |
| **Үр дүн** /ерөнхий дундаж/ | | | | | | **38.5** | **Дунд** |

## 1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2024 онд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгарт үйл ажиллагаа явуулдаг "Монголын алт" (МАК) ХХК–ийн Евро блок үйлдвэр нь 321,600 $м^3$ блок үйлдвэрлэхээр төлөвлөсөн ба уг төлөвлөлтийн дагуу "Дэнжийн элс" уулын хэсэг нь 109,170 $м^3$ цэвэр элс үйлдвэрлэж тус үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөсөн.

Дээр дурьдсан төлөвлөгөөний үйл ажиллагаанаас Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННҮ-ний зөвлөмжүүд дээр үндэслэн тодорхойлж тэдгээрээс урьдчилан сэргийлэх, багасгах, бууруулах, ажлыг доорх зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалах, хамгаалах
- Байгаль орчны хяналтаар илэрсэн эрсдэл, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах бууруулах арга хэмжээг зохион байгуулах
- Монгол улсын Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах.
- Уулын хэсгийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, арчилгаа, тордолгоог сайжруулах, тогтмолжуулах
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах талаар заавар зааварчилгааг ажиллагсдад сургалтыг хэлбэрээр өгөх.

- Дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, орон нутгийн иргэдэд байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах
- Хог хаягдлын менежментийг сайжруулах

# 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1 Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд

**2.1.1 Зам талбайн усалгаа** Уурхайн үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу Дэнжийн элс-1 уулын хэсгийн дарга дотоод замын сүлжээг баталсан бөгөөд зөвхөн батлагдсан замаар үйл ажиллагаа явуулах зааварчилгааг нийт ажилчдад өдөр тутмын наряд дээр сануулан, уулын мастер тогтмол хяналт тавьж ажилладаг ба салхи шуурга, хуурайшилт ихтэй үе буюу 5-8 саруудад тоос шороо их байгаа зам талбай, дотоод тээвэр, овоолгуудын усалгааны хэмжээг нэмэгдүүлж, тухайн өдрийн цаг агаараас хамааран 32 тонны усалгааны машинаар тогтмол усалгаа хийж, агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллалаа.

*Хүснэгт 7 Зам усалгаанд ашигласан усны хэмжээ*

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Усны машин | рейс | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 0 | 0 | 15 |
| Усны хэмжээ | м3 | 0 | 0 | 0 | 0 | 32 | 32 | 64 | 32 | 64 | 32 | 0 | 0 | 256 |
| Нийт зам талбай | км | 0 | 0 | 0 | 0 | 4 | 6 | 6 | 6 | 4 | 6 | 0 | 0 | 32 |




*Зураг 15 Зам талбайн усалгааны явц*

**2.1.2 Агаарын чанарын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын хүрээнд**: БОННҮ-нд заагдсаны дагуу дараах хяналтын цэгүүдэд улирал тутам Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгүүлсэн ба нийт тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, дуу чимээний үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан. Үүнд

1. **Олборлолтын талбай, шигшүүр орчим**
2. **Хогийн цэг, ШТМ хадгалах талбай**
3. **Тээврийн зам**

***Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн***

*График 1 Агаарын сорилтын дүн*




*График 2 Дуу чимээний сорилтын дүн*



Дээрх хэмжилтийн дүнгээр үзэхэд агаар бохирдуулагч бодисын хэмжээ Монгол улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016 болон Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны ерөнхий шаардлага MNS 4990:2010 стандартуудыг хангаж байна. Дуу чимээний сорилтын дүнд уурхайн тээврийн дуу чимээ ерөнхий шаардлагаас ялимгүй давсан үзүүлэлттэй байна. /***Шинжилгээний хариуг хавсаргав*** /



*Зураг 16 Агаарын хэмжилтийн багаж, явц*

**2.1.3 Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарт хяналт тавих** Үйл ажиллагааны явцад замын тоосжилтыг багасгахын тулд батлагдсан зам талбайгаар зөвшөөрөгдсөн хурдаар тээвэрлэлт хийхэд уулын мастерууд тогтмол хяналт тавьж сөрөг нөлөөллийг бууруулж ажиллаж байна.




*Зураг 17 Хурдны хязаар*

## 2.2 Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч үзүүлэлх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд

### 2.2.1 Шимт хөрсний хуулалт, тээвэрлэлт хадгалалтыг стандартын дагуу хийх

Шимт хөрсний овоолго үүсгэх хадгалах үйл ажиллагааг ТЭЗҮ, БОННҮ болон "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS 5916:2008 стандартын дагуу налууг 18-22 градусын налуутайгаар хэвгийжүүлэн хадгалалтад хяналт тавьж , шимт хөрсний овоолгын өндөржилт 5 м , налуугийн тогтвортой байдлыг хангаж ажиллалаа. Мөн шимт хөрсний овоолгод мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн ба шимт хөрсний үндсэн үзүүлэлтүүдийг хангаж нөхөн сэргээлтэд ашиглаж болохоор байна . ***/Шинжилгээний хариуг хавсаргав /***




***Зураг 18 Шимт хөрсний хадгалалт***

**2.2.2 Мод тарих ажил:** "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд болон БОМТ-д тусгагдсаны дагуу өөрийн эзэмшил талбайн гал тогооны урд хэсэг, явган хүний зам дагуу, зүүн хойд хэсэг, хурлын танхимын урд хэсэгт гацуур 15 ш, нарс 25 ш, монос 10 ш, үхрийн нүд 50 ш, шар хуайс 100 ш нийт 200 ширхэг мод бут тарьсан. Орон нутагт тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Налайх дүүргийн 5-р хороонд 100 ширхэг хайлаас модны суулгацыг тарих заавар, зөвлөмжийн хамт өгсөн. Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд НБОГ-с өгсөн чиглэлийн дагуу Сонгинохайрхан дүүргийн, 21 дүгээр хороонд байрлах "Инчон мөрөөдлийн төгөл"-д 1666 ширхэг шинэс, хайлаас модыг тарьсан.



***Зураг 19 Уурхайн талбайд мод тарих явц***




***Зураг 20 Орон нутагт мод хүлээлгэн өгөх явц***



***Зураг 21*** "Инчон мөрөөдлийн төгөл"-д мод тарих явц

**2.2.3** Газрын гадарга хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд уулын инженер, мастер, байгаль орчны мэргэжилтэн нар эзэмшил талбайд техникийн болон явган хүний олон салаа зам гаргахгүй байхад хяналт тавьж ажилчдад сургалт мэдээлэл, зааварчилгааг тогтмол өгч ажиллалаа.

**2.2.4** ШТМ-ын асгаралтаас урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд:
Уурхай нь хүнд машин механизмын засвар, үйлчилгээ, тээврийн хэрэгслүүдээс асгаралт үүсэж газрын гадарга хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэн засвар үйлчилгээг тогтмол зориулалтын талбайд хийж тос масло асгарахаас сэргийлэн зориулалтын сав тосож засвар үйлчилгээг хийж байна Хөрсөнд тос масло асгарсан тохиолдолд тухай бүр нь Аюултай хог хаягдал алдагдсан тохиолдолд авах арга хэмжээний журмын дагуу мэдээлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж бохирдсон хөрс болон бусад материалыг аюултай хог хаягдал хадгалах талбай болон хөрс саармагжуулах талбайд хадгалж эзэмшил газрын хэмжээнд болон ойр орчимд бохирдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна.

Засварын үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдал болох хаягдал тосыг зориулалтын талбайд зориулалтын битүүмжлэл бүхий саванд хадгалж аюултай хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй "Түмэн эгшиг" ХХК-тай байгуулсан "Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ"-ний дагуу нийлүүлж байна. 2024 оны 10 сарын байдлаар 4.3 тн хаягдал тосыг хүлээлгэн өгч устгалд оруулсан байна.



*Зураг 12 Аюултай хог хаягдал хадгалах талбай*



*Зураг 23 Засвар үйчилгээний төв*





*Зураг 24 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг*

**2.2.5 Хөрсний мониторинг хийх** БОННҮ-д заасан хуваарийн дагуу улирал тутам хогийн цэг, аюултай хог хаягдал хадгалах талбай, бохирын цооног орчим хүнд металлын бохирдол үүсэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор итгэмжлэгдсэн лаборатори болох Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор холбогдох стандартуудын дагуу улирал тутам шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх хүнд металлын агууламж нь MNS5850:2008 стандартаас давсан үзүүлэлт байхгүй үйлдвэрийн хөрс хүнд металлаар бохирдоогүй хэмээн үзэж байна./ ***Шинжилгээний дүнг тайланд хавсаргав/.***

***Хүснэгт: 8 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн***

| № | Он | Цэгийн нэр | Sr | Cd | Pb | Cu | Zn | Cr |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ppm | ppm | ppm | ppm | pmm | pmm |
| 1 | 2024.07.23 | Хог хаягдлын цэг | 300 | 0.05 | 14 | 28 | 50 | 0.5 |
| | 2024.09.13 | | 320 | 0.5 | 10 | 29 | 40 | 0.5 |
| 2 | 2024.07.23 | Аюултай хог хаягдал хадгалах талбай | 419 | 1.2 | 14 | 29 | 0.5 | 0.5 |
| | 2024.09.13 | | 460 | 0.5 | 11 | 29 | 0.5 | 0.5 |
| 3 | 2024.07.23 | Бохирын цооног орчим | 269 | 0.05 | 9 | 28 | 2 | 0.5 |
| **Хүлцэх агууламж /MNS 5850:2019/** | | | **800** | **3,0** | **100,0** | **100,0** | **300,0** | **150,0** |
| **Хортой агууламж /MNS 5850:2019/** | | | **1000,0** | **10,0** | **500,0** | **400,0** | **500,0** | **600,0** |
| **Аюултай агууламж /MNS 5850:2019/** | | | **1800,0** | **20,0** | **1200,0** | **1500,0** | **1000,0** | **1000,0** |

## 2.3 Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд

**2.3.1** Усны хэрэглээг батлагдсан загварын дагуу тогтмол бүртгэж, хяналт тавьж байх ажлын хүрээнд уурхайн унд ахуй, үйлдвэрлэлд ашиглаж буй 3 гүний худгийн тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээний хугацаа энэ онд дуусгавар болж стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулалтыг дахин хийлгэсэн ба уулын хэсгийн мастерууд өдөр, шөнийн ээлжид ажиллаж ээлж хүлээлцэх бүртээ гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг тогтмол шалгаж усны хэрэглээг батлагдсан загварын дагуу тогтмол бүртгэж хяналт тавьж ажиллаж байна.

*Хүснэгт: 9 Худгийн мэдээлэл*

| № | Худгийн дугаар | Байршил | Гүн,м | Уст үе | Тогтсон түвшин, м | Ундарга л/с | Хатуулаг PH |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 11000-12600-12700-04190 | 4748`01.73" 107 29`22.98" | 80.0 | 56-76 | 35 | 2.5 | 3.6 7.3 |
| 2 | 01/2022 | 4748`01.5" 107 29`04.0" | 31.0 | 15-27 | 14.80 | 2.0 | 2.22 7.34 |
| 3 | 11000-12600-12700-10712 | 4748`16.36" 107 29`28.71" | 60.0 | 40-56 | 34.26 | 2.0 | 2.79 7.58 |


СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
MASM
УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ 165284
МАК -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXSG 25 загварын 3,5 м³/ц
хэмжих хязгаартай, 25 мм-ийн голчтой № 1911000099 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2026 оны 06 -р сарын 12 -ны өдөр хүртэл усны
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.
Шалгалтын дараах заалт: 00149 м³
Лабораторийн тамга
Усны шалгагчийн гарын үсэг, тэмдэг
2024 оны 06 -р сарын 12 -ны өдөр



*Зураг: 25 Тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ* *Зураг: 26 Усны хэрэглээний бүртгэл*

**2024 онд ашигласан усны хэмжээ**

***Хүснэгт 10 Усны хэрэглээ***

| № | Эх үүсвэр | Зориулалт | Ус ашиглах хэмжээ $м^3$ Дүгнэлтээр | Тоолуураар |
|---|---|---|---|---|
| 1 | Гүний худаг | Үйлдвэрлэл | 164,846.70 | 4898 |
| 2 | | Унд ахуй | 1,226.40 | 224 |
| 3 | | Зам талбай, ногоон байгууламж | 2340.0 | 256 |
| **Нийт** | | | 168,413.10 м3/жил | 5,378 м3/жил |

2024 оны 10 сарын байдлаар унд ахуйд 224 $м^3$, тоосжилт дарах зам талбай ногоон байгууламжийн усалгаанд 256 $м^3$, үйлдвэрлэлд 4898 $м^3$, Нийт 2024 онд **5,378 $м^3$** ус ашигласан байна.

***График:3 Усны хэрэглээ***




**2.3.2 Усны чанарын мониторинг:**Уурхай нь улирал тутам гүний ус, унд ахуйн ус, хаягдал уснаас сорьц авч усны чанарын үндсэн үзүүлэлт, бактериологийн үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн лаборатори болох Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор, Ханлаб ХХК-р шинжлүүлэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлыг ханган хяналт тавьж ажиллаж байна. /***Шинжилгээний дүнг хавсаргав/***

*Хүснэгт:11 Бактерологийн шинжилгээний дүн*

| *Үзүүлэлт* | *Стандарт* | *Нэгж* | *Зөвшөөрөгдөх дээд хэмжээ* | *Ундны ус* |
|---|---|---|---|---|
| Бактерийн ерөнхий тоо | MNS ISO 6222:1998 | 1 мл-д | 100 | 2 |
| Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо | MNS ISO 9308-1:1998 | 100 мл-д | илрэхгүй | илрээгүй |
| Калиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо | MNS ISO 9308-:1998 | 100 мл-д | илрэхгүй | илрээгүй |
| Гэдэсний бүлгийн эмгэг торогч нян | MNS ISO 19250:2017 | 25 мл-д | илрэхгүй | илрээгүй |
| Clkstridiun perfringens | MNS ISO 6461-2:1998 | 100 мл-д | илрэхгүй | илрээгүй |

**2.3.3** Гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг тогтмол шалгаж, гүний худгуудын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж ажиллалаа.





*Зураг: 27 Гүний худгуудын тэмдэглэгээ*

## 4. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд

4.1 Амьтны тухай хууль, тогтоомжийг ажилчдад танилцуулж, бүртгэл мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд нийт ажилчдад батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу амьтны бүртгэлийг сайжруулах, амьтдыг хамгаалах талаарх сургалт мэдээллийг өгч ажилчдыг идэвхжүүлэн хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллалаа.

Уурхайн талбай нь төв суурин газартай ойр байрлах учир зэрлэг ан амьтан тохиолдох боломжгүй. Талбайд цөөн зүйлийн төв суурин амьдралтай шувууд болон туулай үзэгдэж амьтны бүртгэлд бүртгэгдэж байна. Үүнд: Хон хэрээ, болжмор, тагтаа, шаазгай улаан хошуут жунгаа зэрэг байна.





*Зураг: 28 Амьтны үзэгдэл, бүртгэл*

**5. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд**

5.1.1 Уурхайн нь ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана.

Уурхайн эзэмшил талбайд жижиг дэгнүүлт үетэн- агь - шарилжилт бүлгэмдэл зонхилох ба үетэнээс Дэрвээн хазаар өвс, Том цэцэгт дааган сүүл Биелэг өвс, Саман ерхөг зонхилох бөгөөд Агь, Зогдор улалж, Тарваган харгана алаг өвснөөс Дэлхээ тогторгоно, Толгодын бударгана Удвал навчит тавилгана, Ишгүй гичгэнэ, Божлог шарилж зэрэг 6 овог 11 төрлийн 12 зүйлийн ургамал ургаж байна.

***Хүснэгт: 12 Ургамлын жагсаалт, зүйлийн бүрэлдэхүүн***

| дд | Ургамлын нэр /латин/ | Монгол нэр |
|---|---|---|
| 1 | Cleistogenes squarrosa /Trin/ Keng | Дэрвээн хазаар өвс |
| 2 | Koeleria macrantha /Ldb/ Schult | Дааган сүүл |
| 3 | Poa attenuate Trin | Сунагар биелэг өвс |
| 4 | Agropyron cristatum | Саман ерхөг |
| 5 | Carex pediformis C.A.Mey | Зогдор улалж |
| 6 | Caragana pugmaea /L/ DC | Тарваган харгана |
| 7 | Kochia prostrata /L/ Schrad | Дэлхээ тогторгоно |
| 8 | Salsola collina | Толгодын бударгана |
| 9 | Spiraea aguilegefolia Pall | Удвал навчит тавилгана |
| 10 | Potentilla acaulis L | Ишгүй гичгэнэ |
| 11 | Artemisia anethifolia web.ex. Stechm | Божмог шарилж |
| 12 | Artemisia frogida willd | Агь |

Дээрх ургамалжилтын зүйлийн бүрдэл, эвшилд 06-09 сарuудын хооронд хяналт тавьж, бүртгэл, ажиглалтыг хийж ажиллалаа.



*Зураг: 29 Ургамлын бичиглэлийн явц*

## 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн техник эдийн засгийн үндэслэлийн V-р бүлгийн Байгаль орчин, нөхөн сэргээлт, хаалтын хэсэгт уурхайн ашиглалт явуулсан талбайг хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхээр тусгасан ба ашиглагдсан талбайн нөхөн сэргээлт, цаашдын ашиглалтын нөхцөл бүрдүүлэх ажил хөдөө аж ахуйн чиглэлээр тэгшилж засах талбайн гадаргууд зохистой өнцгийг (хэвгийг) үүсгэхээр ажиллаж байна. 2024 онд 12 $м^3$ талбайд шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолго үүсгэсэн. Шимт хөрсний овоолго үүсгэх хадгалах үйл ажиллагааг ТЭЗҮ, БОННҮ болон "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS 5916:2008 стандартын дагуу налууг 18-22 градусын налуутайгаар хэвгийжүүлэн хадгалалтад хяналт тавьж хөрс, шимт хөрсний овоолгын өндөржилт, налуу, тогтвортой байдлыг хангаж ажиллаа. Мөн шимт хөрсний овоолгод мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн ба шимт хөрсний үндсэн үзүүлэлтүүдийг хангаж нөхөн сэргэлтэд ашиглаж болохоор байна.

**Ашиглалтын үеийн техникийн нөхөн сэргээлтээр** уурхайн хоосон орон зайг дүүргэх, тэгшлэх, хэлбэржүүлэх, ухашийн хажууг налуулах болон шимт хөрсөөр хучих, суваг шуудуу татах зэрэг ажлууд хийгдсэн. Уурхайн ойр орчмын зам, талбайд үүсэх хөрсний эвдрэл, гэмтлийг тэгшлэх, түрэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Ашиглалтын үеийн биологийн нөхөн сэргээлтээр у**урхайн шимт хөрсний овоолгыг Хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхэд бэлдэж тэгшилж талбайн гадаргууд зохистой хэвгийг үүсгэх ажлууд нэмж хийгдэх тул уурхай эзэмшил талбайн шаардлагатай газруудад салхинаас хамгаалах, тоосжилтыг бууруулах зорилгоор зүлэг, мод, бутаар нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба энэхүү ажлын хүрээнд зүлэгжүүлсэн талбайн хэмжээ 200 $м^2$ , уурхайн зүүн хойд хэсэг, гал тогооны урд хэсэг, явган хүний зам дагуу, хурлын танхимын урд хэсэгт гацуур 15 ш, нарс 25 ш, монос 10 ш, үхрийн нүд 50 ш, шар хуайс 100 ш нийт 200 ширхэг мод бутыг тарьж ургууллаа. Уурхайн эзэмшил талбайд нийт 9 төрлийн 1028 ширхэг мод, бут ургаж байна. Мод бутны тайралт, таналт, усалгаа арчилгаа зэргийг тогтмол хийж гүйцэтгэлээ.



*Зураг: 30 Зүлэгжүүлсэн талбай*



*Зураг: 31 Ногоон байгууламж*

## 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтөй аж ахуйн нэгжүүд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар НБОГ-с Нийслэлийн нутаг дэвсгэрийн 8 байршлаас сонгож нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажлыг хийж гүйцэтгэх чиглэлийг өгсний дагуу бид Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах "Инчон мөрөөдлийн төгөл"-д ойн зурвас байгуулах ажилд оролцож дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төсөвлөсөн мөнгөн дүнгээр /*20.000.000* төг/ 3 настай  хайлаас, шинэс бүхий 1,666 ширхэг модыг тарьсан. Уг талбайд энэ жил нийт 2,998 ширхэг мод тарьгдсан байна. /***Ажлын тайланг хавсаргав***/



*Зураг: 32 "Инчон мөрөөдлийн төгөл"-д мод тарих явц*




*Зураг: 33 Тайланд тусгагдсан байдал*

# 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛ

Уурхайн нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн барилга байгууламж, үйлдвэрлэлийн төвлөрсөн хэсэгт хамаарч байгаа бөгөөд тус дүүргийн 5-р багийн Дэнжийн элсний уурхайн ойр орчимд нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдах айл өрх байхгүй юм.

# 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт эхлэхээс өмнө 2012 онд Соѐлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу ШУА-ийн Археологи ба Палеонтологийн төвөөр хайгуул, судалгааг хийлгэсэн бөгөөд тус хайгуул судалгаагаар археологи, палеонтологийн ямар нэгэн олдворт зүйл байхгүй гэсэн дүгнэлт гарсан.

Төслийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн барилга байгууламж, үйлдвэрлэлийн төвлөрсөн хэсэгт хамаарч байгаа тул тусгайлан "Түүх соѐлын өвийг хамгаалах төлөвлөгөө" боловсруулах шаарддлагагүйг БОННҮ-д зөвлөсөн байдаг.

Гэсэн хэдий ч уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдож болзошгүй тул үйл ажиллагааны явцад санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соѐлын өвийг хамгаалах хууль болон компанийн "Санамсаргүй олдворын үед ажиллах журам"-ыг дагаж мөрдөн ажиллана. Төлөвлөгөөт онд үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соѐлын олдвор илрээгүй болно.

# 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### *7.1 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Уурхай нь Компанийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа "Хортой ба аюултай бодисын менежментийн төлөвлөгөө"-г хэрэгжүүлж ажиллаж байна. Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай техникийн тос, маслыг Евро блокийн үйлдвэр болон компанийн Улаанбаатар хот дахь Техник үйлчилгээний төвөөс олгодог бөгөөд бага хэмжээний тосолгооны материалуудыг уулын хэсгийн сэлбэг, хэрэгслийн агуулахад хадгалж ашиглаж байгаа бөгөөд ашиглалт хадгалалтад уулын мастер болон нярав тогтмол хяналт тавьж ажилладаг. Ахуйн хэрэгцээнд хэрэглэгдэх цэвэрлэгээний бодисуудыг аж ахуйн агуулахад хадгалж байна.

## 7.2 Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлт

- ✓ Хавар намрын цаг агаарын хуурайшилтын үед цахилгааны эх үүсвэрүүд, машин тоног төхөөрөмжийн яндангаас оч хаяулахгүй байх техникийн нөхцөлийг бүрдүүлж хяналт тавьж ажилласан.
- ✓ Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг бүх ажиллагсдад өгч болзошгүй түймрийн үед ажиллах график төлөвлөгөө гаргаж мөрдөн ажиллаж байна.
- ✓ Гал унтраах багаж хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж зохих газруудад байрлуулсан ба галын машины бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна.




*Зураг:34 Галын аюулгүй байдлын самбар, зааварчилгаа*



*Зураг:35 Уурхайн галын машин*

### 7.3 Уурхайн догол, мөргөцөгт нуралт үүсэхээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө

Уурхайд ашиглалтын үед хөрс хуулалтыг орхигдуулж ашиглалтын системийн хэмжээснүүдийг мөрдөөгүйгээс доголын өндөр хэвийн хэмжээнээс өндөр болж нуралт үүсэх нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай. Иймд

Нуралт үүсэхээс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллалаа

- Нуралт үүсэж болзошгүй газарт анхааруулах тэмдэг тавьсан
- Хөрс хуулалт, элс хайрга олборлолтын зохистой харьцааг тогтмол хянаж байна.
- Уурхайн ашиглалтын системийн хэмжээснүүдийг мөрдөж ажиллаж байна.

## 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхай нь хог хаягдлыг ахуйн хог хаягдал, хүнсний хог хаягдал, дахивар хог хаягдал, аюултай хог хаягдал гэсэн байдлаар ангилан ялгаж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг гэрээний дагуу хогийн цэгт зайлуулна.

- ✓ Овор ихтэй төмөр болон модон хаягдлыг түр хадгалах талбайд хадгалж аж ахуйн болон бусад зориулалтаар дахин ашиглаж байна.
- ✓ Хүнд машин механизмын засвар үйлчилгээнээс гарсан бага хэмжээний тосыг цуглуулан зориулалтын битүүмж алдагдахааргүй саванд түр хадгалж, дүүрсэн үед нь "Түмэн Эгшиг" ХХК-тай хийсэн гэрээний дагуу дуудлага өгч нийлүүлж байна.
- ✓ Хуурай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж ерөнхий хог хаягдлыг "Налайх Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-тай хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ байгуулан зайлуулж байгаа ба гэрээний дагуу төлбөрийг төлж барагдуулж байна.
- ✓ Дахивар хог хаягдлуудаас хуванцар сав, шил, лааз кординон цаас зэргийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж цуглуулж Төвшин сайхан төвд тушааж байна. 2024 оны 10 сарын байдлаар уурхайн ахуйн хэрэглээнээс гарсан дахин боловсруулах боломжтой 80 кг хуванцар сав, 100 гаруй хаягдал шилийг уг төвд тушааж эдийн засгийн эргэлтэд оруулсан.
- ✓ Уурхайн талбайн зоогийн газрын хойд талд 100 м3 багтаамж бүхий бохир усны бетон цооног байгуулсан ба Чандмань Налайх ДЭХГ-ын ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байна. / ***гэрээг хавсаргав*** /
- ✓ Хог хаягдлын менежментийг сайжруулахын тулд уурхайн нийт ажилчдад сургалт орж, мэдээллийн самбарт ангилан ялгалтыг сайжруулах мэдээллийг тогтмол оруулж,

хог хаягдлыг эргүүлэн ашиглах эко шийдэл бүтээлийн уралдааныг зарлан ажилчдыг идэвхжүүлж, урамшуулж ажиллаж байна.



*Зураг:36 Хогийн цэг, Аюултай хог хаягдал хадгалах талбай*



*Зураг:37 Бохирын танк*



*Зураг:38 Хөрс саармагжуулах талбай*



*Зураг:30 Хог хаягдлыг эргүүлэн ашиглах эко шийдэл тэмцээний удирдамж*

# 9. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгаж хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрд үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

<u>НЭГ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ</u>

1.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл
- ❖ Төслийн талбайн хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл

1.2. Хяналт - шинжилгээ явуулсан үзүүлэлт:
- ❖ Хөрсний өнгөн үе давхаргын агро химийн үндсэн үзүүлэлт, зонхилох ион, давсжилт, CaO, $SiO_2$
- ❖ Cd, Cr, Hg, Br, Pb, Zn, Cu, Co, Sr, Rb, Zr зэрэг хүнд металлын бохирдлын төвшнийг тодорхойлуулсан.

1.3. Байршил:

Хөрсний бохирдлыг хянах, тархалтын цар хүрээг тодорхойлох үүднээс дараах цэгүүдэд
- ✓ Аюултай хог хаягдал хадгалах талбай
- ✓ Хогийн цэг / хатуу хог хаягдлаас үүсэх бохирдлыг хянах/
- ✓ Бохирын цооног орчим
- ✓ Шимт хөрсний овоолго

1.4. Ажлын дараалал
- ❖ Хөрсний зүсэлтийг (0.5-1.0 м гүн).
- ❖ Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авсан.
- ❖ Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийсэн
- ❖ Дээж авалт (дээж тус бүрд байршил солбилцол бичсэн хаягтай)
- ❖ Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн шинжилгээ хийлгэсэн

1.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график
- ❖ Улирал тутам

1.6. Хэрэглэгдсэн багаж төхөөрөмж
- ❖ Зүсэлт хийх хүрз
- ❖ Хөрс дээжлэгч уут, сав
- ❖ Фото аппарат

1.7. Аргачлал

- MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- MNS 3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- MNS 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.

<u>ХОЁР. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ</u>

2.1. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

- Гүний усанд бохирдол дамжих

2.2. Хяналт-шинжилгээ явуулсан үзүүлэлт

- Усны чанарын үндсэн үзүүлэлт, Био идэвхт нэгдлүүд
- Бактериологийн үзүүлэлтүүд
- Ахуйн бохир усны үзүүлэлтүүд

2.3. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- Сорьц авч шинжилгээ хийлгэсэн

2.4. Байршил

- Гүний худгууд
- Бохирын цооног
- Гал тогоо

2.5. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, сав

2.6. Итгэмжлэгдсэн лабораторийн хэмжилтийг улирал тутам хийлгэсэн.

2.8. Аргачлал

- MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ
- MNS 5667-10:2001 Усны чанар- Ахуйн хаягдал усны дээж
- MNS 4867:1999 Усны чанар- Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах
- MNS (ISO) 5667-6:2001 Усны чанар Гүний уснаас дээж авах

2.9. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010
- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюул байдлын үнэлгээ MNS900:2005

<u>ГУРАВ. АГААР ОРЧНЫ БОХИРДОЛ</u>

3.1. Хяналт шинжилгээ явуулсан үзүүлэлтүүд:

- Агаар дахь $NO_2$, $SO_2$-ийн агууламж, тоос PM10, PM2.5, дуу чимээ

3.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:

- Сорьц авах (агаар, тоос,)
- Хэмжилт хийх ($NO_2$, $SO_2$,тоосжилт, дуу шуугиан)

3.3. Байршил

Тоосжилтоос үүсэх агаар бохирдлыг хянах

- ❖ Шигшүүр /Салхины чиглэлийн дагуу эх үүсвэрээс 20-30 м зайд/
- ❖ Хогийн цэг /Салхины чиглэлийн дагуу эх үүсвэрээс 20-30 м зайд/
- ❖ Олборлолтын талбай орчим /Салхины чиглэлийн дагуу эх үүсвэрээс 20-30 м зайд/
- ❖ Уурхайн тээврийн зам
- ❖ Уурхайн кемп /Салхины чиглэлийн дагуу эх үүсвэрээс 20-30 м зайд/

3.4. Хийсэн ажлын дараалал:

- ❖ Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулж
- ❖ Цаг агаарын төлөв байдлын талаар орчны бичиглэлийг хийсэн.
- ❖ Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлсөн.
- ❖ Зориулалтын автомат багажны тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэсэн.

3.5. Хяналт шинжилгээ явуулсан хугацаа, давтамж:

- ❖ Өөрийн багажаар хийх хэмжилтийг сар бүр
- ❖ Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээг улирал тутам хийлгэсэн.

3.6. Хяналт шинжилгээ явуулсан арга, аргачлал:

- ❖ MNS 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих
- ❖ MNS 0017-5.1.21:92. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга
- ❖ MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс

3.7. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:

- ➢ MNS 0012-013:91. Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага
- ➢ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007
- ➢ Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885 : 2008
- ➢ MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- ➢ MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

Агаар, ус, хөрсний шинжилгээг улирал тутам мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор дээрх аргачлал дарааллын дагуу хийж гүйцэтгүүлж холбогдох стандартуудтай харьцуулж үзэхэд стандартаас давсан үзүүлэлтгүй байгаа болно. /***Шинжилгээний хариунуудыг хавсаргав/***

*Хүснэт 13 Орчны хяналт шинжилгээний зардал .*

| Хяналт шалгалт хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүл эгч | Хамтран хэрэгжүүлэгч | Баримтлах хууль стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хөрс | | | | |
| Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд | Шимт хөрсний овоолго, Засварын талбай, хогийн цэг, Уурхай орчим, Аюултай хог хаягдал хадгалах талбай | Удаа | 2 дээж 4 удаа | 68,500 | 205,500 | МАК Дэнжийн элс | ГЗГЭХ-ийн Хөрс судлалын лаборатори, ЦУОШГ-н харьяа БОХЗЛ | MNS 5850:2008 |
| Хүнд металлын шинжилгээ /12 элемент/ | | Удаа | 2 дээж 4 удаа | 45,000 | 405,000 | | | |
| Дүн | | | | | **610,500** | | | |
| | | | | Агаар | | | | |
| $NO_2$, $SO_2$ | Олборлолтын талбай, шигшүүрийн дэргэд, дотоод тээврийн зам Уурхайн кемп | Удаа | 3 дээж 4 удаа | 15,000 | 180,000 | МАК Дэнжийн элс | ЦУОШГ-н харьяа БОХЗЛ | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007 |
| Тоос PM10, PM2.5 | | | 3 дээж 4 удаа | 30,000 | 360,000 | | | |
| Дуу чимээ | | | 3 дээж 4 удаа | 4,500 | 54,000 | | | |
| Дүн | | | | | **594.000** | | | |
| | | | | Ус | | | | |
| Усний хими | Худаг 1,2,3 | Удаа | 4 | 60500 | 242,000 | МАК Дэнжийн элс | Ханлаб ХХК, ЦУОШГ-харьяа БОХЗЛ | MNS 0900:2010 |
ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

## СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/372
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : МАК Дэнжийн элс
Сорьц авсан хүний нэр,албан тушаал : Б.Дашням
Сорьцын тоо,төрөл : 1 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2024.07.23
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар-Налайх дүүрэг 5-р хороо
Шинжилгээний аргын стандарт : MNS 3310:1991
Шинжилсэн огноо : 2024.08.03
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Чийг % | pH | Ялзмаг % | Аммоний азот ($NH_4$-N) мг/кг | Нитратын азот ($NO_3$-N) мг/кг | Фосфор ($P_2O_5$) мг/кг | Сульфат ($SO_4$) мг/кг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шимт хөрсний овоолго | 1.07 | 7.01 | 1.95 | 29.5 | 2.6 | 1.26 | 18.8 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч У.Болорчимэг

Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/373-375
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : МАК Дэнжийн элс
Сорьц авсан хүний нэр,албан тушаал : Б.Дашням
Сорьцын тоо,төрөл : 3 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2024.07.23
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар-Налайх дүүрэг 5-р хороо
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2024.07.26
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Бохирын цооног орчим | <0.05 | 9 | <0.005 | <0.5 | 2 | 28 | 269 |
| 2 | Хогийн цэг орчим | <0.05 | 14 | <0.005 | <0.5 | 50 | 28 | 300 |
| 3 | Хаягдал тос хадгалах талбай | 1.2 | 14 | <0.005 | <0.5 | <0.5 | 29 | 419 |
| MNS 5850:2019/ ЗДХ/ | | 3 | 100 | 2 | 150 | 300 | 100 | 800 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ИТГЭМЖЛЭЛИЙН ... ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ ҮЛ0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

MNAS Accreditation system

БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/373-375 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас | : МАК Дэнжийн элс |
| Сорьц авсан хүний нэр,албан тушаал | : Б.Дашням |
| Сорьцын тоо,төрөл | : 3 хөрсний сорьц |
| Сорьц авсан огноо | : 2024.07.23 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар-Налайх дүүрэг 5-р хороо |
| Шинжилгээний аргын стандарт | : САЗ А01:2022 |
| Шинжилсэн огноо | : 2024.07.26 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Бохирын цооног орчим | <0.05 | 9 | <0.005 | <0.5 | 2 | 28 | 269 |
| 2 | Хогийн цэг орчим | <0.05 | 14 | <0.005 | <0.5 | 50 | 28 | 300 |
| 3 | Хаягдал тос хадгалах талбай | 1.2 | 14 | <0.005 | <0.5 | <0.5 | 29 | 419 |
| **MNS 5850:2019/ ЗДХ/** | | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

УИ 0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/A-41 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "МАК ДЭНЖИЙН ЭЛС" |
| Сорьцын авсан хүний нэр, албан тушаал | : Д. Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 2 агаар, 2 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2024.03.19 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот Налайх дүүрэг 3-р хороо |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021<br>MNS 5002:2000, САЗ А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2024.03.21 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Дотоод тээврийн зам шигшүүр | III/19 | 13:20 | 0.010 | 0.036 | 0.064 | 50 |
| 2 | Кэмп баян хогын цэгийн дунд | III/19 | 13:45 | 0.018 | 0.024 | 0.078 | 44 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

MNAS Accreditation system

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/А-148

Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : МАК дэнжийн элс

Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Б. Дөлгөөн агаарын хэсэг

Сорьцын тоо, төрөл : 3 агаар, 3 дуу чимээ

Сорьц авсан огноо : 2024.06.24

Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот Налайх дүүрэг 5-р хороо

Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016

Шинжилсэн огноо : 2024.06.27

Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Шигшүүр олборлолтын талбай орчим | VI/24 | 12:20 | 0.008 | 0.034 | 0.152 | 73 |
| 2 | Тээвэрлэх зам | VI/24 | 12:40 | 0.011 | 0.043 | 0.138 | 63 |
| 3 | Кемп | VI/24 | 13:00 | 0.009 | 0.027 | 0.100 | 51 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

БАТЛАВ: "МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК -ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ГАМУУН

.......................................

БАТЛАВ: "НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ЭРДОЛ

.......................................

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 01 сарын 02 өдөр № 162-2424 Улаанбаатар хот

Нэг талаас: Монгол Улсын Улаанбаатар хотноо байрлаж, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй "Монголын Алт" (МАК) ХХК /цаашид **"Захиалагч"** гэх/, түүнийг төлөөлж Барилгын материал үйлдвэрлэлийн газрын захирал В.Шагдарсүрэн,

Нөгөө талаас: "Налайх тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ /цаашид **"Гүйцэтгэгч"** гэх/, түүнийг төлөөлж Гэрээний мэргэжилтэн С.Оюунгэрэл нар /цаашид хамтад нь **"Талууд"** гэх/ харилцан тохиролцож Хог хаягдлын тухай хууль түүний шинэчилсэн найруулга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан "Хот тохижилт цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам", Налайх дүүргийн ИТХурлын 2022 оны 19/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн энэхүү гэрээг /цаашид **"Гэрээ"** гэх/-г дараах нөхцөлөөр байгуулав.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Захиалагчийн МАК Евроблок үйлдвэрийн үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэгдэн ирснийг бүртгэж хүлээн авах, буулгах, түрэх, зайлуулах /цаашид "ажил үйлчилгээ" гэх/ үйлчилгээ үзүүлэх, Захиалагч нь үзүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбогдсон харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, тэдгээрээс үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.

1.2. Энэ гэрээн нь Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

1.3. Энэхүү гэрээ нь 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2026 оны 01 сарын 01–ны өдөр хүртэлх 2 жилийн хугацаанд хүчинтэй байна. Шаардлагатай бол Талууд нэмэлт гэрээ байгуулж гэрээний хугацааг сунгаж болно.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ, ХУГАЦАА.

2.1. МАК Евроблокийн үйлдвэрээс тээвэрлэгдэн ирсэн хогийг бүртгэж хүлээн авах, буулгах, түрж булах, зайлуулах ажил үйлчилгээний төлбөрийг 1 рейс **110,000** */нэг зуун арван мянган/* төгрөгөөр тооцох бөгөөд жилийн үнэ нь рейсийн гүйцэтгэлийн тоогоор гарна. Энэхүү үнэд НӨАТ болон ажил үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүхий л зардал бүгд багтсан болно.

2.2. Талууд гэрээний 2.1-д заасан ажил үйлчилгээний гүйцэтгэлийг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор дүгнэн тооцоо нийлж акт үйлдэж баталгаажуулна.

2.3. Захиалагч гэрээний 2.2-т заасан актыг үндэслэн зөвхөн Гүйцэтгэгчээс үзүүлсэн ажил үйлчилгээнд дүйцэх төлбөрийг төлж барагдуулна.

2.4. Гүйцэтгэгч нь нэхэмжилж буй үнийн дүнгээр НӨАТ-ын баримт /падаан/-ыг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд Захиалагч гэрээний үнээс НӨАТ-ыг суутгана.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**3.1. <u>Захиалагчийн эрх, үүрэг:</u>**

3.1.1. Гүйцэтгэгчээс гэрээнд заасан ажлыг тухай бүрд, бүрэн гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

3.1.2. Энэхүү гэрээнд заасны дагуу үнийг төлөх үүрэгтэй.

МОНГОЛЫН АЛТ (МАК) ХХК

3.1.3. МАК Евроблок үйлдвэрээс гарсан хог хаягдлыг өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн Гүйцэтгэгчийн хогийн цэгт хүргэх үүрэгтэй.
3.1.4. Хогийг хогийн цэгт буулгах бүрд Гүйцэтгэгчийн диспетчерт мэдэгдэх үүрэгтэй.

**3.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

3.2.1 Захиалагчаас гэрээний 2.2-т заасны дагуу гэрээний үнийг төлөхийг шаардах эрхтэй.
3.2.2 Гэрээнд заасан ажлыг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэх үүрэгтэй.
3.2.3 Захиалагчийн тээвэрлэн ирсэн хогийг бүртгэж, буулгах талбайг зааж өгөх үүрэгтэй.
3.2.4 Буулгасан хогоо торж зайлуулах, талбайн чөлөөлөх ажлыг өөрийн зардлаар бүрэн хийж гүйцэтгэх үүрэгтэй.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан бодит хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
4.2. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээ нь МУ-ын холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцээгүй тохиолдолд түүнээс учирсан шууд болон шууд бус аливаа хохирлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар бүрэн хариуцна.

## ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Аль нэг тал нөгөө талаас урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй.
5.2. Энэхүү гэрээ хэрэгжих явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
5.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан маргаатай асуудлыг Талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
5.4. Талууд энэхүү гэрээг 3 хувь үйлдэж Захиалагч 2 хувь, Гүйцэтгэгч 1 хувийг хадгалах бөгөөд гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй байна.

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

| | |
|---|---|
| “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК | “НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ |
| Регистр: 2095025 | Регистр: 26044663 |
| Хаяг: УБ хот, ХУД, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, Төв байр-44 | Хаяг: УБ хот, Налайх дүүрэг, Даваажавын гудамж, ЭМН-ийн урд өөрийн байр |
| Утас:7575-9700 | Утас:7023-2219 |

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэгчийг төлөөлж: |
| БМҮГ-ын Захирал<br>В.Шагдарсүрэн | Гэрээний мэргэжилтэн<br>С.Оюунгэрэл |

*Монголын Алт (МАК) ХХК*

## ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

**Гэрээний төрөл:** ☐ үндсэн гэрээ , ☑ нэмэлт гэрээ, ☐ гэрээний өөрчлөлт ☐ ________________

| № | Гэрээлэгч Компани | Гэрээний товч утга | Гэрээний үнийн дүн | Гэрээний хугацаа /урьдчилгаа төлөгдсөнөөс хойш/ |
|---|---|---|---|---|
| 1 | Чандмань Налайх ОНӨААТҮГ | Бохир ус | 2,600.0 | Хугацаатай гэрээ 1.0 Жил/Хуанлигийн |

**Гэрээний төслийг хянасан хуульч:** ЭНХ-АРВИЖИХ.Б [ЭЗГ]

**Гэрээ хариуцсан мэргэжилтэн:** ДАШНЯМ

**Нэгж:ХАБЭАБО-ны хэсэг [ХАБЭАБОХ] → [МЕБҮ]**

**Тэмдэглэл:**

№ 0749-2424 тоот гэрээний төслийн зохих хэсгийг хянаж, гэрээ байгуулахыг зөвшөөрөв. Хяналтын хуудсанд гарын үсэг зурсан нь гэрээнд гарын үсэг зурсантай нэгэн адил тооцогдоно.

**Гэрээний төслийг хянасан:**

| № | *Албан тушаал/ Нэр* | *Огноо* | *Үүрэг* | *Санал* | *Саналыг дэлгэрэнгүй бичнэ үү* |
|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч АРИУНТӨГС.Ц [БЗ] | *2024-07-19* | *Хянагч* | *Зөвшөөрсөн* | |
| 2 | Газрын захирал САЙНЖАРГАЛ.Д [СБГ] | *2024-07-18* | *Хянагч* | *Зөвшөөрсөн* | |
| 3 | Газрын захирал БАДАМХАНД.Ж [ДАЧХАБГ] | *2024-07-19* | *Хянагч* | *Зөвшөөрсөн* | |
| 4 | Газрын захирал ЭЗГ ЖАВХЛАН.Т [ЭЗГ] | *2024-07-22* | *Хянагч* | *Зөвшөөрсөн* | |
| 5 | Газрын захирал ШАГДАРСҮРЭН.В [БМҮГ] | *2024-07-19* | *Оролцогч* | *Зөвшөөрсөн* | *Zuvshuursun* |

**Гэрээ батлуулах үйл явцын дараалал:**

1. ЭЗГ-аас хянагдан дугаарлагдсан гэрээний төсөл, хяналтын хуудсыг авах;
2. ЭЗГ-аар хянагдаагүй тохиолдолд гэрээг ЭЗГ-т бүртгүүлж, бүртгэлийн дугаар авах;
3. Хяналтын хуудсанд заагдсан албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулах /*Гарын үсэг бүрэн байх* /;
4. Ерөнхийлөгчид танилцуулж, гэрээг батлуулах;
5. Гэрээнд тамга даруулах, огноо тавих;
6. ЭЗГ-т гэрээний нэг хувийг хяналтын хуудас, цохолт, бусад дагалдах бичиг баримтын хамт хүлээлгэн өгөх.

***Санамж:*** *Гэрээнд 1.Хяналтын хуудас 2.Ерөнхийлөгчийн зөвшөөрөл эсхүл СШХ-ны шийдвэр 3.ДАЧХХАБГ-ын дүгнэлт 4.Гэрээлэгч талын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар заавар зэргийг хавсаргаж ЭЗГ-т хүлээлгэн өгнө.*

- ☐ Хяналтын хуудас бүрэн зурагдсан эсэх
- ☐ Цохолт
- ☐ Хяналтын төсөв
- ☐ Гэрээлэгчийн баримт бичиг /УБГ, ТЗ гэх мэт/
- ☐ Огноо
- ☐ Дардас
- ☐ Инишиал
- ☐ Гарын үсэг бүрэн эсэх
- ☐ Тамга бүрэн эсэх
- ☐ Хавсралт бүрэн эсэх
- ☐ Хоосон зай, гараар бөглөх хэсгийг орхисон эсэх
- ☐ Эх хувь мөн эсэх

БАТЛАВ

ЧАНДМАНЬ-НАЛАЙХ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.ГАНЗОРИГ

БАТЛАВ

МАК ХХК ерөнхийлөгч ...

# АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2024 оны 07 сарын 18-ны өдөр №Н2024-749-2424 Налайх дүүрэг

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол улсын "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль"-ийн 13-р зүйлийн 13.2 дахь заалт, Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Нэг талаас "Чандмань-Налайх" ОНӨААТҮГ /цаашид Хангагч гэх/-ыг төлөөлж Хуулийн зөвлөх ажилтай Б.БАТЧИМЭГ нөгөө талаас МАК ХХК /цаашид Хэрэглэгч гэх/- төлөөлж үйлдвэрийн дарга ажилтай Д.Баасандоржин нар нь 2024 оны 07 сарын 18-ны өдрөөс 2025 оны 04 сарын 01-ны өдөр хүртэл хугацаатай дор дурдсан нөхцөлийг биелүүлж ажиллахаар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

## Хоёр. Хэрэглэгчийн эрх, үүрэг

2.1 Гэрээний дагуу бохир ус нийлүүлэх.

2.2 Хангагч болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг "Чандмань-Налайх" ОНӨААТҮГ-ын диспетчерийн 70233310, 89953310 утсаар болон байгууллагын удирдлагад мэдээлэх, гомдол гаргах.

2.3 Өөрийн эзэмшлийн бохир ус нийлүүлэх үйлчилгээтэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах

2.4 Хэрэглэгч нь Налайх дүүрэг 5 дугаар хорооны цэвэрлэх байгууламжийн худагт бохирыг нийлүүлэх.

2.5 Хэрэглэгч нь бохир ус хүлээн авах ажилтны заасан худагт бохирыг нийлүүлж, баримтжуулан баримт авах.

2.6 Хэрэглэгч нь бохир ус нийлүүлэх төлбөрийг тухай бүр төлөх.

2.7 Хангагч байгууллагатай заасан хугацаанд гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх

2.8 Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох бүрд гэрээнд тодотгол хийлгэх

2.9 Хэрэглэгч нь бохир усыг заасан худагт хийх ба бохир ус нийлүүлэх стандарт "MNS.6561:2015"-д стандартын шаардлагад нийцсэн бохир усыг нийлүүлнэ. Химийн бодис агуулсан буюу усанд уусахгүй бүхэл биет агуулсан, мах цус, яс, хог орсон бохир ус нийлүүлэхийг хатуу хориглоно. Тийм төрлийн бохир нийлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах, дахин гэрээ байгуулахгүй байх хүртлэх арга хэмжээг хангагч тал авна.

2.10 Хэрэглэгч гэрээ байгуулахдаа хангагчид байгууллагын гэрчилгээний хуулбар, бохир зөөвөрлөх машины гэрчилгээний хуулбарыг өгөх, хаягын мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх, гэрээнд хавсаргах үүрэгтэй.

## Гурав. Хангагчийн эрх, үүрэг

3.1 Хэрэглэгчид бохир ус нийлүүлэх стандарт шаардлагын талаар мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх

3.2 Хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр төлбөртэй үйлчилгээ үзүүлэх

3.3 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэхгүй байх, гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлөхийг шаардах.

3.4 Хангагч нь хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авч, 24 цагийн дотор барагдуулах.

3.5 Хэрэглэгчийн захиалга болон дуудлагаар засвар үйлчилгээний ажлыг батлагдсан үнэ тарифаар хийх.

3.2.5 Ажилтны буруугаас шалтгаалан хэрэглэгчээс илүү төлбөр авсан бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлэх

## Дөрөв. Төлбөр тооцооны журам

4.1 Гэрээний үнэ 185,000 төгрөгийг хэрэглэгч тал гэрээ байгуулахдаа төлнө. Баримтыг гэрээнд хавсаргана.

4.2 Хэрэглэгч нь бохир усыг Налайх дүүрэг, 5 хороо, городокын цэвэрлэх байгууламжийн худагт бохир усыг зөөвөрлөх бөгөөд 1 тн бохир усыг.....2,600.................. төгрөг, /НӨАТ-гүй/ тооцож, гэрээний дагуу төлбөр тооцоо хийнэ.

4.3 Үйлчилгээний төлбөрийг тухайн сарын 25-ны дотор "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын ХАС БАНК- 5000192357 дансанд тушаана.

4.4 Үйлчилгээний сар бүрийн төлбөрийг тухайн сарын 25-ны өдөр төлөөгүй хэрэглэгчдэд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөрийн үнийн дүнгийн 0,5%-иар тооцон алданги тооцно.

## Тав.Талуудын харилцан хүлээх үүрэг хариуцлага

5.1 Хоёр тал Иргэний хууль, Усны тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

5.2 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба тохиролцоогүй тохиолдолд хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Хангагч хэрэглэгчийн хооронд гарсан үйлчилгээ, төлбөр тооцоотой холбогдсон маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.2 Гэрээний үүргээ биелүүлээгүй хоёр тал харилцан эс зөвшөөрвөл хуулийн байгууллагаар шийдүүлнэ.

## Долоо: Бусад зүйл

7.1 Гэрээг 3% үйлдэж талууд авна. Гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй.

7.2 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцалж болох ба энэ тухай хангагчид 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

7.3 Гэрээг цуцлахдаа үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулсан байна.

7.4 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба тохиролцоогүй тохиолдолд Хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

7.5 Үнэ тарифт өөрчлөлт орох бүрд хангагч энэ тухай хэрэглэгчдэд 30 хоногийн өмнө албан мэдэгдэл болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэх ба үнэ тарифын хэрэгжилт нь эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөгдөнө.

7.6 Гэрээнд хоёр тал харилцан тохиролцож нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7.7 Гэрээг жил бүр сунгаж, тодотгол хийнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| **ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ** |
| ХУУЛИЙН ЗӨВЛӨХ | үйлдвэрийн дарга |
| ................ Б.БАТЧИМЭГ | ................ Ш. Бадамдамдин |
| Утас: 86163838 | Утас: 91911638 |
| Хаяг: Налайх дүүрэг, 2 хороо, | Хаяг: |

(МАК)

БАТЛАВ:
"МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК
-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦОЛМУУН

УЛААНБААТАР ХОТ МАК МОНГОЛЫН АЛТ (МАК) ХХК ТТН1008 2095025

..............................

БАТЛАВ:
"ТҮМЭН ЭГШИГ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЧИНЗОРИГ

УЛААНБААТАР ТҮМЭН-ЭГШИГ ХХК ТТГ1045 5051923

..............................

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 10 сарын 13.-ний өдөр № 964-1121 Улаанбаатар хот

Нэг талаас **"Түмэн-Эгшиг" ХХК** /цаашид **"Хүлээн авагч"** гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр,

Нөгөө талаас **"Монголын Алт" (МАК) ХХК** /цаашид **"Үүсгэгч"** гэх/, түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар бид нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын *2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал* болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч түр хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Энэ гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Үүсгэгч гэдэгт "Монголын Алт" (МАК) ХХК болон дор дурдсан түүний охин болон хамаарал бүхий компанийг хамтад нь ойлгоно. Үүнд:

1.3.1. "МАК Цемент" ХХК;

1.3.2. "Хүрэн толгой коал майнинг" ХХК;

1.3.3. "Эрдэнэс цагаан суварга" ХХК;

1.3.4. "Тру ти ар си" ХХК.

1.4. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

### ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээ хийсэн байна.

2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.

2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.

2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ *БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг* бүрдүүлж өгнө.

2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис */тухайлбал цианид натри гэх мэт/* -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

## ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2021 оны 10 сарын 13-ны өдрөөс 2022 оны 10 сарын 13-ны өдрийг хүртэл 1 (нэг) жилийн хугацаатай байна.

3.2. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com и-мэйл хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлоно.

3.4. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

3.5. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний Хавсралт №1-т заасан төлбөр тооцооны тарифт үнээр тооцож аюултай хог хаягдлыг шилжүүлнэ.

3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед Үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрснөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.

3.7. Хүлээн авагч нь Үүсгэгчийн ирүүлсэн аюултай хог хаягдлыг Хавсралт №1-т заасан тарифт үнээс 5 хувийн хөнгөлөлттэй үнээр устгана.

3.8. Үүсгэгч нь гэрээний 3.5, 3.6-д заасан төлбөрийг "Түмэн-Эгшиг" ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкны **499085408** тоот дансанд нэхэмжлэхийн дагуу төлнө. Үүнд:

- 3.8.1. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийн 40 хувийг,
- 3.8.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэн өгч дагалдах бичгийн 1 хувь буцан ирснээс хойш ажлыг 5 хоногийн дотор төлбөрийн үлдэгдлийг.

3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд Хавсралт №2-т заасан үнийн дагуу Тээвэрлэлтийн зохих төлбөрийг төлнө.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:

- 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
- 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
- 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
- 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
- 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг Хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
- 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч хариуцна.
- 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа Хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

4.2.1 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал Үүсгэгчийн төлөөлөгчид мэдэгдэж зохих арга хэмжээг авах үүрэгтэй.

4.2.2 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог Үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.

4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.

4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.

4.2.5 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

## ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших Хүлээн авагчийн аюултай хог хаягдал устгах үйлдвэрт хүргэнэ.

5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.

5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.

5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч хүлээн авна.

5.5. Хүлээн авагч нь үүсгэгчийн шилжүүлэн өгсөн аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хууль, болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам"-ын шаардлагад нийцүүлэн хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах ажиллагааг хариуцан гүйцэтгэх бөгөөд түүнийг зөрчсөний улмаас үүссэн хариуцлагаас Үүсгэгчийг ангид байлгана.

5.6. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөс хойших аливаа асуудалд хариуцлаа хүлээхгүй болно.

## ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.7.2-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.

7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.2-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.

7.4. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хуулиар зохицуулна.

7.5. Үүсгэгч аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлснээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.

7.6. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.

8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

## ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Талуудын аль нэг нь гэрээний 3.1-т заасан хугацаа дуусгавар болсны дараа Гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд Гэрээг дахин 1 жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.3. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр долоон хувь үйлдэж, Үүсгэгч 6 хувь, Хүлээн авагч 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Үүсгэгчийг төлөөлж:**
ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

..............................................

Хуульч Б.Жанчив

..............................................

**Хүлээн авагчийг төлөөлж:**
Ерөнхий менежер Б.Одбаяр

..............................................

964-1121 .................................. тоот гэрээний Хавсралт №1

**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**

*(тээврийн зардал багтаагүй үнэ болно)*

| № | Үйлчилгээний төрөл | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгж үнэ /төг/ НӨАТ тооцоогүй дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, | тн | 1 | 1150000 |
| 2 | Химийн хуванцар торх / 100л/ | ш | 1 | 4800 |
| 3 | Химийн хуванцар торх /200л/ | ш | 1 | 5600 |
| 4 | Химийн хуванцар IBC танк /1000л/ | ш | 1 | 20000 |
| 5 | Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/ | тн | 1 | 1250000 |
| 6 | Төмөр торх поошиг | ш | 1 | 4200 |
| 7 | Химийн бодисын шил,сав | кг | 1 | 1500 |
| 8 | Капель,Тигл шаазан сав | кг | 1 | 1600 |
| 9 | Химийн хаягдал шингэн уусмал 1литр | л | 1 | 3500-4500 |
| 10 | Хаягдал аккумлятор | ш | 1 | 5000 |
| 11 | Масло шүүр том оврын | ш | 1 | 3800 |
| 12 | Принтер хор | ш | 1 | 2500 |
| 13 | Хаягдал агаар шүүгч филтэр | ш | 1 | 4000 |
| 14 | Хаягдал лаг | тн | 1 | 950000 |
| 15 | Хаягдал цаас | кг | | 400 |
| 16 | Хаягдал маск болон бээлий нийлэг материал | кг | 1 | 1500 |
| 17 | Хаягдал шингээгч даавуу химийн бодистой | кг | 1 | 3500 |
| 18 | Хаягдал төмөр материал болон бусад | кг | 1 | 2500 |
| 19 | Хаягдал лааз сав | ш | 1 | 1100 |
| 20 | Хаягдал батарей | кг | 1 | 3500 |
| 21 | Ашигласан масло тос | 1 литр | 1 | 800 |
| 22 | Хөргөлтийн шингэн тосол | 1 литр | 1 | 1000 |
| 23 | Галын хорны баллон том жижиг/дунд | 1ш | 1 | 3500-4800 |

964-1121

| | | | | |
|---|---|---|---|---|
| 24 | Бохирдсон хөрс тостой | тонн | 1 | 1600000 |
| 25 | Эмнэлгийн хаягдал | кг | 1 | 5500 |
| 26 | Хаягдал аккумлятор | кг | 1 | 3500 |
| 27 | Хаягдал Battery | кг | 1 | 1800 |
| 28 | Хаягдал дугуй /том/ | ш | 1 | 12000-25000 |
| 29 | Хүчил ба шингэн хаягдал | л | 1 | 4200 |
| 30 | Азотын хүчил | г | 1 | 4200 |
| 31 | Аммиак | г | 1 | 4200 |
| 32 | Давсны хүчил | кг | 1 | 3800 |
| 33 | Хүхрийн хүчил | кг | 1 | 3800 |
| 34 | Цууны хүчил | кг | 1 | 3800 |
| 35 | Фосфорын хүчил | кг | 1 | 3800 |
| 36 | Хлорт натри | кг | 1 | 4200 |
| 37 | Техникийн сальфитка, Алчуур шингээгч даавуу | кг | 1 | 3500 |
| 38 | Натри | л | 1 | 3500 |
| 39 | Хуурай бодис | кг | 1 | 4200 |

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**Үүсгэгчийг төлөөлж:**
ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

..................................................

**Хүлээн авагчийг төлөөлж:**
Ерөнхий менежер Б.Одбаяр

..................................................

964-1121

........................................ тоот гэрээний Хавсралт №2

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ҮНЭ**

| № | Машины марк, даац | Засмал зам | Шороон зам | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Хүнд даац: 25-30 тн<br>Машины марк: | 1км/4800 төг | 1км/4800 төг | Үүсгэгч аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачих зардал ороогүй буулгах зардал орсон үнэ болно. |
| 2 | Бага даац: 3 тн, 5 тн<br>Машины марк: | 1км/3500 төг | 1км/3500 төг | |

Тайлбар:

1. Дээрх тээвэрлэлтийн хөлсөнд НӨАТ тооцоогүй үнэ бөгөөд тээвэрлэлтийн зардлыг 1 талд нь тооцсон үнэ болно.

1.1 НҮБ-ын 2010 оны аргачлал, Монгол Улсын химийн бодисын тухай хууль, Монгол Улсын химийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS 4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөдөлмөр аюулгүй ажиллагааг хангаж тээвэрлэнэ.

1.2 Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмын дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**Үүсгэгчийг төлөөлж:**
ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.............................................................

**Хүлээн авагчийг төлөөлж:**
Ерөнхий менежер Б.Одбаяр

.............................................................

3

9 6 4 - 1 1 2 1

*Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын*
*2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар*
*тушаалын 1 дүгээр хавсралт*

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ**
**№**

**Дагалдах бичгийн дугаар:**
*/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /*

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: ....................................

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

| Овог нэр | Албан тушаалтан | Гарын үсэг: | Огноо: |
|---|---|---|---|
| ............................ | ..................... | .................. | 2021он .......... сар.....өдөр |

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: ......................... Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....................

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал зэрэглэл | Савлагааны бүлэг | Савны | | Хэмжээ | Нэгж /кг Эсвэл/ ш | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дугаар | Төрөл | | | |
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |

**4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :**

1. Овог нэр:..................................... Гарын үсэг:.............................. 2021он ......... сар............өдөр

**7. Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**
Аж ахуйн нэгжийн нэр: **“Түмэн-Эгшиг” ХХК**
“Түмэн-Эгшиг” ХХК бүртгэлийн дугаар: **0000001**

**Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:**

| Овог нэр : “Түмэн-Эгшиг” ХХК | Албан тушаал | Гарын үсэг/ тамга / | Огноо |
|---|---|---|---|
| ............................ | ...................... | ........................... | 2021 он .... сар ... өдөр |

1

БАТЛАВ: "МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ТЭЛМҮҮН

БАТЛАВ: "ТҮМЭН-ЭГШИГ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЧИНЗОРИГ

**0964-1121 тоот гэрээний нэмэлт гэрээ**

2024 оны 02 сарын 20-ны өдөр №235-1124 Улаанбаатар хот

**Нэг талаас** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй "Монголын Алт" (МАК) ХХК (Регистрийн дугаар: 2095025) (цаашид "**Үүсгэгч**" гэх), түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар,

**Нөгөө талаас** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй "Түмэн-Эгшиг" ХХК (Регистрийн дугаар: 5031923) (цаашид "**Хүлээн авагч**" гэх), түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр нар (цаашид хамтад нь "**Талууд**" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль болон Талуудын хооронд 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулагдсан 0964-1121 тоот "Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ" (цаашид "**Үндсэн гэрээ**" гэх)-ний 9.3 дугаар зүйлийг тус тус үндсэн дараах гэрээ (цаашид "**Нэмэлт гэрээ**" гэх)-г байгуулж байна.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Нэмэлт гэрээний зорилго нь Үндсэн гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссантай холбогдуулан Үндсэн гэрээний 3.1-д заасан хугацааг сунгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү Нэмэлт гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд Үндсэн гэрээ болон Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

## ХОЁР. ҮНДСЭН ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ

2.1. Үндсэн гэрээний 3.1-д заасан хугацааг 1 *(нэг)* жил буюу 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгав.

2.2. Нэмэлт гэрээний 2.1-д заасан хугацаа дуусгавар болсны дараа Талууд харилцан тохиролцож нэмэлт гэрээ байгуулснаар Үндсэн гэрээг дахин 1 *(нэг)* жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.

## ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

3.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

3.2. Талууд энэхүү Нэмэлт гэрээг адил хүчинтэй 7 *(долоо)* хувь үйлдэж, Үүсгэгч 6 *(зургаа)* хувь, Хүлээн авагч 1 *(нэг)* хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

3.3. Энэхүү Нэмэлт гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд байгуулсан Үндсэн гэрээний хугацаа сунгагдсанд тооцно.

3.4. Энэхүү Нэмэлт гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцаа нь Талуудын хооронд байгуулагдсан 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 0964-1121 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу зохицуулагдана.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Үүсгэгчийг төлөөлж:**

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

________________________

ЭЗГ-ын Ахлах хуульч Т.Жавхлан

________________________

**Хүлээн авагчийг төлөөлж:**

Ерөнхий менежер Б.Одбаяр

________________________

Нийслэлийн байгаль орчны газар

Нури ХХК

ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-НД ТУСГАГДСАНЫ ДАГУУ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Танилцсан:

НБОГ-ын дарга

Р.Энхтайван

Танилцсан:

НБОГ-ын Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн хэлтсийн дарга

О.Тэмүүжин

Хянасан:

НБОГ-ын ХБОБНХ-ийн Газрын хэвлийн хяналт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн:

С.Сухцоож

Улаанбаатар хот

2024 он

## ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 83 зарлиг "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2021 оны 56 дугаар зарлиг "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 27 дахь заалт "Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх", ажлын хүрээнд ойн мэргэжлийн байгууллага "Нүри ХХК" үндсэн болон гэрээт ажилчдыг зохион байгуулан 33 дахь заалт "Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд мод тарих, ургуулах, арчлах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх", нийслэлд 120 сая мод тарих батламж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт "Ногоон ажлын байр хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн, хууль бус мод бэлтгэл болон сөрөг нөлөөлөлд өртсөн ойн нөхөн сэргээлт хийх, цөлжилтөөс болж шар шороон шуурганаас сэргийлэн ойн зурвас байгуулах ажлыг Инчон мөрөөдлийн төгөлд 4 га талбайд дүйцүүлэн хамгаалах ажлыг 2 дахь жилдээ тарьж байна.

## АЖЛЫН ЗОРИЛГО

"Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх зорилготой бөгөөд дараах зорилтуудыг төлөвлөж ажилласан.

Үүнд:

1. Ойн зурвасын ажлын талбайн хэмжээг судалгаанд хамрагдсан газар нутгийн хүрээнд тогтоох
2. Судалгаанд хамрагдаж байгаа газарт ямар зүйлийн мод зонхилон ургаж болохыг тогтоох
3. Ойн зурвасын ажлыг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн.

Ойн зурвасын ажлыг Нийслэлийн байгаль орчны газар, "Нүри" ХХК-ны инженер, техникийн ажилтанууд Үүнд:

Гүйцэтгэгч:

- "Нүри" ХХК-ны захирал Х.Лхагважав
- "Нүри" ХХК-ны ойн инженер А.Номин
- "Нүри" ХХК-ны техникч Э.Гансүх

Орон нутгийн улирлын түр ажилчин нийт 15 хүн хамтран ажилласан.

4. **Ойн зурвасын ажлыг гүйцэтгэж буй газар.**

Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21 хороонд байрлах "Инчон мөрөөдлийн төгөлд":

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд шинэс, хайлаас мод тарьж ургуулсан газар**



5. **Ойн зурвасын ажлын бэлтгэл, зохион байгуулалт.**

Ажил эхлэхийн өмнө тухайн газарт хийх ажлаа танилцуулж, хамтарч ажилласан.
**Бэлтгэл ажлын хүрээнд**

- Ойн зурвасын ажилд хэрэглэгдэх тоног төхөөрөмж болох 2 ширхэг моторт газар ухагч болон нүх ухагч трактор гэрээний дагуу нүх ухагчийг ажилд бэлтгэв.
- Ойн зурвасын ажилд ашиглах 1:50 000-ын сансарын болон 1:9900-ны масштабтай талбайн тойм зураг дээр ойн зурвасын ажил явуулах талбайг тэмдэглэн ажлын зураг бэлтгэсэн





- Ойн зурвасын ажилд хэрэглэх 3 настай бортоготой шинэс тарьц болон 3 настай хайлаас модыг тарилтанд бэлтгэсэн.

- Ойн зурвасын ажилд ажиллах ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг өдөр бүр өгч ажилласан.
- Ойн зурвасын ажлын мод тарьсны дараах усалгааны ажилд шаардлагатай усалгааны сав болон машин техник бэлэн болгосон.







**6. Гэрээний дагуу дараах ажлыг гүйцэтгэв.**

<u>*Үүнд:*</u>

- Талбайдаа мод тарих стандартын дагуу 5713 нүх ухав.
- 3 настай шинэс мод 1500ш
- 3 настай хайлаас мод 3113ш
- 4 настай нарс 1100ш
- 3 настай 3113 ш хайлаас, 1100ш нарс, 1500 ш шинэсийг намрын тарилтад бэлтгээд нэмэлтээр усны машин түрээслэж 10 хоногт 52 тонн усаар усалж байв.

Санхүүжилтын хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэв.

- Нүх ухаж тарилтанд бэлгэхэд
- Модны үнэ
- Холбогдох зардлыг тухай аж ахуйн нэгж байгууллагаад хариуцсан болно.

7. **Ойн зурвасын ажлыг гүйцэтгэсэн хугацаа**

Ойн зурвасын ажлыг 2024 оны 05-р сарын 05 -с 10-р сарын 26-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

Үйл ажиллагаа фото зураг

Мод тарих газрын тэмдэглэгээ хийж байгаа зураг



Трактороор модны нүх ухаж байгаа зураг



Тарих 3 настай шинэс модны зургууд





Тарьсан шинэс модны зургууд







Тарьсан хайлаас модны зураг



Моднуудаа тарьчихаад услаж байгаа зурагнууд





Тарьчихаад услаж байгаа зураг



Модоо усласан байгаа зураг

## Мод тарьхад оролцсон ААН байгууллагууд

1. Цэээцээ импекс ХХК 250ш
2. Цэээцээ импекс ХХК 250ш
3. Цэээцээ импекс ХХК 125ш
4. Мөнх сонор ХХК 250ш
5. Монгол алт МАК ХХК 1666ш
6. Батшил ХХК 166ш
7. Күнлүн ХХК 208ш
8. Наран Хан булаг ХХК 83ш
9. Мерсу ХХК 83ш

Нийт 2,998ш мод тарилаа.

Тайлан гаргасан Нури ХХК захирал Х.Лхагважав